

7-Р АНГИЙН ХИМИ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Анги ... бүлэг ...

Сурагчийн нэр

Хугацаа: 60 минут

Нийт оноо:43

ХУВИЛБАР А**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ** /Даалгавар тус бүр 1 оноотой/

1. Дараах бодисын төлөв байдал болон үзэгдлийг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу.

1	Ус-мөс	R	Конденсаци
2	Мөс-ус	S	Хайлах
3	Ус-уур	T	Хөлдөх
4	Уур-ус	U	Уурших

- a. 1U2T3S4R b. 1R2S3T4U c. 1T2S3U4R d. 1T2U3S4R

2. Химийн лабораторт үнэртэй хий агуулсан савны крантыг нээжээ. Савны ойр байсан хүмүүс тэр даруйдаа хийн үнэрийг мэдэрчээ энэ ямар үзэгдэл вэ?

- a. Хайлах b. Диффуз c. Уурших d. Уусах

3. Дараах бодисуудаас химийн элементийг сонгоно уу.

- a. Агаар b. Зэс c. Сода d. Ус

4. Дараах өгөдлөөс холимгийг сонгоно уу.

- a. Төмрийн сульфид b. Давсны хүчил c. Натрийн хлорид d. Давсны уусмал

5. Хар саарал өнгөтэй, хатуу, амархан давтагддаг, уян харимхай соронзлогдох шинжтэй металлыг сонгоно уу?

- a. Зэс b. Төмөр c. Алт d. Мөнгө

6. Зөв харгалзуулна уу.

1. Натри a. Холимог
2. Натрийн хлорид b. Нэгдэл
3. Хлор c. Металл
4. Хүхэр ба төмөр d. Металл биш

- a. 1b2c3a4d b. 1d2c3a4d c. 1c2b3d4a d. 1a2b3c4d

7. Химийн элементүүдийн нэр ба химийн тэмдгийг харгалзуулна уу.

№	Элементийн нэр		Химийн тэмдэг
1	Устөрөгч	А	N
2	Хүчилтөрөгч	Б	O
3	Нүүрстөрөгч	В	C
4	Азот	Г	H

- a. 1B2A3Г4Б b. 1Г2Б3B4A c. 1A2Б3B4Г d. 1Б2Г3A4B

8. Ямар аргыг ашиглан элс, давсны холимгийг ялгаж болох вэ?

- a. Соронзлогдох b. Ууршуулах c. Шүүх d. Нэрэх

9. Шил хагарах, лаа асаах, төмөр зэврэх, сүү гашлах, цаас хайчлах, хадаас нугалах зэрэг үзэгдлүүдээс хэд нь физик үзэгдэл вэ?

- a. 2 b. 3 c. 4 d. 5


10. Химийн урвалын үгэн тэгшитгэлийн эх бодис ба бүтээгдэхүүн бодисыг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу.

Эх бодис		Бүтээгдэхүүн бодис	
1	Магни+ус →	X	Магнийн хлорид+устөрөгч

2	Магни+хүхрийн хүчил →	Y	Магнийн сульфат+устөрөгч
3	Магни+давсны хүчил →	Z	Магнийн гидроксид+устөрөгч

- a. 1X2Y3Z b. 1X2Z3Y c. 1Z2Y3X d. 1Z2X3Y

11. Гэрийн нөхцөлд цууны хүчилд гараа түлсэн тохиолдолд ямар хэмжээ авах вэ?
 a. Хүйтэн усаар угаах b. Содын уусмалаар угаах
 c. Мөсөөр жин тавих d. Спиртийн уусмалаар арчих
12. Химийн бодис хүчилтөрөгчийн орчинд гэрэл, дулаан ялгаруулан явагдах урвалыг..... урвал гэнэ.
 a. халах b. исэлдэх c. Шатах d. Практикийн ач холбогдолгүй урвал
13. Сурагч хөрсний рН-ийг судалсан үр дүнг диаграммаас харна уу. Хөрсний саармаг байх үеийг сонгоно уу.



- A. 11 B. 9 C. 8 D. 7


14. Зэвэрлээс хамгаалах арга аль нь биш вэ?
 A. Усаар угаах B. Тослох C. Будах D. Бүрэх
15. Металлын идэгдэх үзэгдлийг.....гэнэ.
 A. Муудах B. Гандах C. Өгөрших D. Корроз
16. Сурагчид хөрсний шинж чанарыг судлах даалгавар авчээ. Туршилтаа явуулахад шаардлагатай багаж төхөөрөмжийг сонгон авсан байна. Сурагчид шинжлэх ухаанч арга барилын аль шатны үйлдлийг хийж байгааг сонгоно уу.
 A. Таамаглал дэвшүүлэх, шинэ санаа гаргах
 Б. Шинжлэн судлах ажлыг төлөвлөх
 B. Баримт нотолгоо гаргах, тайлагнах
 Г. Баримт нотолгоо, үр дүнг нягтлах, үнэлэх
17. Ургамал ургадаг, түүнд шаардлагатай шим тэжээлт бодис агуулсан газрын гадаргын өнгөн үе давхрааг..... гэнэ.
 A. Элс B. Шавар C. Хөрс D. Шороо
18. Хөрсний химийн найрлагыг зөв илэрхийлсэн хариултыг сонгоно уу.

	Органик бодис %	Агаар %	Ус %	Эрдэс бодис %
a	25	25	47	25
b	3	47	25	25
c	47	25	25	3
d	3	25	25	47

19. Монгол орны нийт газар нутгийн хэдэн хувь нь ямар нэгэн байдлаар цөлжилтөд өртсөн гэж тодорхойлогдсон байдаг вэ?
 a. 90 b. 56 c. 100 d. 72
20. Хог хаягдлаа багасгах нь хөрсний бохирдлыг бууруулахад ямар нөлөө үзүүлэх вэ?
 a. сөрөг b. эерэг c. муу d. ихэсгэх

ХОЁРДУГААР ХЭСЭГ /Даалгавар тус бүр 3 оноотой/

21. Сурагч зэс, төмөр, цайр, хөнгөнцагаан гэсэн 4 металлын цахилгаан дамжуулалтыг судалжээ.




Металлын нэр	Цахилгаан дамжуулах шинж %
Зэс	95%
Хөнгөнцагаан	59%
Цайр	26%
Төмөр	16%

- а. А,В,С,Д металлуудыг нэрлэнэ үү.....
- б. Аль металлаар цахилгаан дамжуулагч утас хийвэл илүү сайн бэ?
.....
- в. Цахилгаан дамжуулагч утас хийхэд чухал өөр 1 шинж чанарыг нэрлэнэ үү.
.....

22. Дараах өгөгдлийг ашиглан шатах урвалын үгэн тэгшитгэл бичнэ үү.

- а. Цайр шатаж цайрын оксид үүсгэнэ
.....
- б. Фосфор шатаж фосфорын оксид үүсгэнэ
.....
- в. Зэс шатаж зэсийн оксид үүсгэнэ.
.....

23. Дараах даалгаварыг гүйцэтгэнэ үү. /Зоноо/



- а. Үүссэн уусмалын орчинг тодорхойлно уу.
.....
- б. Фенолфталеин индикатор ямар өнгө үзүүлэх вэ?
.....

24. Төмрийн хэлтэрхий агаар, чийгтэй нөхцөлд исэлддэг. Төмрийн гадаргуу дээр бор өнгийн давхрага үүсдэг. Төмрийг өөр нэг материалаар бүрсэнээр зэврэхээс урьдчилан сэргийлж болдог.

- а. Төмөртэй урвалд орсон агаар дахь хоёр бодисыг нэрлээрэй.
.....
- б. Төмрийн гадаргуу дээрх улаан хүрэн бодисын ахуйн хэрэглээний болон химийн нэр юу вэ?.....
- в. Төмрийг зэврэлээс сэргийлэх 2 материалыг нэрлээрэй.
.....

25. Яагаад орчноо зүлэгжүүлэх, мод тарих нь чухал гэж бодож байна вэ? 3 санал бичнэ үү.

.....

.....

.....

7-Р АНГИЙН ХИМИ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Анги ... бүлэг ...

Сурагчийн нэр

Хугацаа: 60 минут

Нийт оноо:43

ХУВИЛБАР Б**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**

1. Харгалзуулаарай.

	Бодис		Жишээ
1	Хий бодис	А	Зэс утсыг ямарч хэлбэр дүрстэй болгож болдог
2	Хатуу бодис	Б	Хуванцар савнаас жимсний шүүсийг шилэн аяганд юүлж болдог
3	Шингэн бодис	В	Дулаарахад голын мөс хайлдаг
4	Төлвийн шилжилт	Г	Дугуй болон шаарыг дүүргэдэг

А. 1А, 2Б, 3В, 4Г

В. 1Б, 2В, 3А, 4Г

С. 1Г, 2А, 3Б, 4В

D. 1В, 2А, 3Г, 4Б


2. Зураг юуг харуулсан байна вэ?

А. Хайлах

В. Уурших

С. Хөлдөх

D. Диффуз



3. Бүгд нэгдэл байгаа хэсгийг сонгоорой.

А. Натри, хлор, хүчилтөрөгч

В. Натрийн хлорид, ус, нүүрсхүчлийн хий

С. Агаар, далайн ус, монет

D. Магни, хоолны давс, устөрөгч

4. Өөр хоорондоо холбогдсон хоёр буюу түүнээс дээш төрлийн атомаас тогтсон химийн бодисыг.....гэнэ.

А. Атом

В. Молекул

С. Нэгдэл

D. Холимог

5. Металлын шинжид аль нь хамаарах вэ?

А. Хатуу, шингэн хий төлөвтэй

В. Хэврэг, хялбархан бутардаг

С. Цахилгаан дамжуулдаггүй

D. Гялалздаг, уян хатан, давтагддаг

6. Гоёл чимэглэлд хэрэглэдэг, улбар шар өнгөтэй, цахилгаан сайн дамжуулдаг шинжтэй нь аль вэ?

А. Шил

В. Агаар

С. Зэс

D. Ус

7. Ууршуулах аргыг хэрэглэж ямар холимогийг ялгаж, салгаж болох вэ?

А. Цайнаас ханд

В. Давсны уусмал

С. Төмөр элс

D. Айрагнаас архи

8. Хэд хэдэн төрлийн элемент болон химийн нэгдлээс тогтсон бодисыг..... гэнэ.

А. Атом

В. Молекул

С. Нэгдэл

D. Холимог

9. Уусмалд өнгөө өөрчлөх шинж чанартай бодисыг юу гэдэг вэ?

А. Хүчиллэг

В. Саармаг

С. Суурилаг

D. Индикатор

10. Суурилаг бодис аль вэ?

А. Лимон, айраг

В. Ус, давс

С. Сахар, ус

D. Хүнсний сод, саван

11. Аль нь физикийн үзэгдэлд хамаарах вэ?

- A. Бодисын төлөв, хэлбэр хэмжээ өөрчлөгдөх
 B. Шинэ бодис үүсэх
 C. Бодисын найрлага шинж чанар өөрчлөгдөх
 D. Өнгө, үнэр өөрчлөгдөх, хий ялгарах, тунадас үүсэх
12. Элементийн шатах урвалын үр дүнд аль нь үүсэх вэ?
 A. Давс үүснэ B. Хүчил үүснэ C. Оксид үүснэ D. Суурь үүснэ
13. Саармагжих урвал аль тохиолдолд явагдах вэ?
 A. Металл + Хүчил B. Металл + Хүчилтөрөгч C. Металл + Ус D. Хүчил + Суурь
14. Ямар үед төмөр зэвэрдэг вэ?
 A. Төмрийг тосон будгаар будах B. Металлын гадаргууг тослох
 C. Төмрийг давстай халуун усанд байлгах D. Металлыг хуванцар металлаар бүрэх
15. Дараах тохиолдлын алинд нь төмөр зэврэх вэ?
 A. Агааргүй усанд байлгах B. Агаартай усанд байлгах C. Ердийн агаарт байлгах
 D. Бүгд боломжтой
16. Усны буцлах цэг тогтмол байдаг уу?
 A. Тогтмол 100°C буцалдаг
 B. Тогтмол 0°C буцалдаг
 C. Нам дор газар өндөр температурт буцалдаг
 D. Нам дор газар нам температурт буцалдаг
17. Ургамал, амьтны гаралтай, нүүрстөрөгч, устөрөгч, хүчилтөрөгч агуулсан бодисыггэнэ.
 A. Органик бодис B. Эрдэс бодис C. Ус, агаар D. Лаг шороо, элс
18. Ургамал ямар хөрсөнд хамгийн сайн ургадаг вэ?
 A. Хүчиллэг
 B. Саармаг
 C. Суурилаг
 D. Бүх хөрсөнд
19. Химийн бодис болон үйлдвэрийн хаягдал хөрсөнд шингэж, ургамал, амьд организмд сөрөг нөлөө үзүүлэхийггэнэ.
 A. Усны бохирдол
 B. Хөрсний бохирдол
 C. Агаарын бохирдол
 D. Аль нь ч биш
20. Хөрсний бохирдлыг бууруулах арга зам аль вэ?
 A. Өрөөндөө чийгтэй цэвэрлэгээ хийх
 B. Голд хувцас болон машинаа угаахгүй байх
 C. Мод тарих, зүлэгжүүлэх
 D. Утаагүй түлш ашиглах

ХОЁРДУГААР ХЭСЭГ

21. Зурагт үзүүлсэн төлвийн шилжилтийг нэрлээрэй.



- A.....
 B.....
 C.....

22. Материалын металл ба металл биш шинжийг тодорхойлж бичнэ үү?


1. Би бол дулаан муу дамжуулдаг
2. Тасалгааны температурт би хатуу төлөвт оршино.....
3. Би цахилгаан сайн дамжуулдаг.....

23. Хөрсийг бохирдуулагч гол эх үүсвэрүүдийг нэрлэ.

1.
2.
3.

24. Зурагт 3 өөр шинж чанартай хөрсөнд ургасан луувангийн ургацыг дүрсэлжээ. Эдгээр хөрс ямар шинж чанартай болохыг тодорхойлж бичнэ үү?

Ургамлын ургалт хөрсний шинжээс хамаарах



- 1-р хөрс.....
2-р хөрс.....
3-р хөрс.....

25. Дараах урвалын тэгшитгэлийг гүйцээгээрэй.

